

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/002/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhanded@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2024/171/НА-СТА-ТШЗ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 25 № 108

танай _____ -ны № _____ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ш.ЭРДЭНЭБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, 22 дугаар зүйлийн 22.1, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.2.5 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолтой нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэлгээ хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин аймгийн Засаг дарга нэгээс илүү орлогч дарга томилж ажиллуулан, нийт 8,225.6 мянган төгрөгийн цалин олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан,

8225020303

- Амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулсан, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлын төсвөөс 20,000.0 мянган төгрөгийг ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтанд олгосон,
- Жилийн эцэст кассаар дамжуулан 6,750.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй, 38,160.0 мянган төгрөгийн албан томилолтын хуудас, нотлох баримтгүйгээр зарцуулсан,
- Албан хаагчдад олгосон спортын болон ажлын хувцас хэрэгслийн зардал 8,840.0 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсан,
- Жилийн эцэст сумын шатахуун түгээх станцын дансанд 8,283.6 мянган төгрөгийг шилжүүлж, шууд зардлаар тайлагнасан,
- Хэрэгцээ шаардлагагүй 5,000.0 мянган төгрөгөөр ном, хэвлэл бэлтгэсэн,
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчин 23,463.9 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн,
- Нийт 213,757.5 мянган төгрөгийн бичиг хэрэг, урсгал засвар, тавилга хэрэгслийг бэлтгэхдээ худалдан авах ажиллагаа зарлаагүй,
- Шатах тослох материалын тооцоо боддоггүй, эд хариуцагч шатахууны зарцуулалтын тайлан гаргадаггүй, нийт зарцуулсан шатахууны 62.0 хувь буюу 152,931.4 мянган төгрөгийг гаднын байгууллага, иргэний машинд хийн зарцуулсан,
- Нийт 134,347.2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, татварын өр үүсгэсэн,
- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 31,417.2 мянган төгрөгийн буудал, хоол, бэлгийн мөнгийг зарцуулсан боловч анхан шатны баримтгүй,
- Нэгдсэн үндэсний байгууллагаас Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон 145,240.3 мянган төгрөгийн 69.0 хувь буюу 100,335.1 мянган төгрөгийг зарцуулахдаа анхан шатны баримтгүйгээр гүйлгээ хийж, шууд зардлаар тайлагнасан, 9,000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар Жангар арга хэмжээнд зарцуулж, 37,500.0 мянган төгрөгийг өөрийн болон хамаарал бүхий этгээдийн дансаар дамжуулан гүйлгээ хийсэн,
- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 91,732.1 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйл, контент, мэдээ бэлтгэх болон бусад арга хэмжээнд, Зэгүн пресс ХХК-руу 9,028.8 мянган төгрөгийн тээврийн хөлс тус тус шилжүүлсэн боловч гэрээгүй, нотлох баримтгүй зориулалт бусаар зарцуулсан.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Ерөнхийлөгчийн зарлигаар Говь-Алтай аймагт төрийн тахилгат Бурхан буудай уулыг тайх ёслолыг зохион байгуулсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 6,384,809.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан нь өмнөх оноос 910,782.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Засгийн газрын 2021 оны 377 дугаар тушаалаар 51 орон тоотой баталсан ба гүйцэтгэлээр 62 орон тоотой ажиллаж байна. Шинээр архивын барилга ашиглалтад орсонтой холбоотой үйлчилгээний ажилтнууд нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын дагуу шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Гэвч Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 139,945.5 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйл, хоол, буудлын төлбөр, контент, мэдээ бэлтгэх болон бусад арга хэмжээнд нотлох баримтгүйгээр зориулалт бусаар зарцуулсан байна.

Орон нутгийн төсвөөс 790,443.2 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, 77,315.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Тайлант онд цалин, шимтгэлийн зардал 173,437.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 72,205.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 418,045.9 мянган төгрөгөөр бусад зардал 180,203.6 мянган төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй бөгөөд урсгал үйл ажиллагаатай холбоотой 185,230.0 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй нь төсвийн төлөвлөлтийг бодитой бус хийж байгааг харуулж байна.

Бусад асуудал

Тайлант онд 1 хөтөлбөр, 4 зорилт, 156 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас дундаж биелэлт 94.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	869,413,846.9	1,191,659,465.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	100.5
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	100.5
31210	Төгрөг	-	100.5
31213	Арилжааны банк дахь харилцах	-	100.5
33	АВЛАГА	112,018,257.9	373,051,896.8
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,121,636.3	1,469,768.2
33101	Цалингийн авлага	1,121,636.3	1,469,768.2
33500	Бусад авлага	110,896,621.6	371,582,128.6
33510	Байгууллагаас авах авлага	52,367,752.6	313,555,859.9
33520	Хувь хүмүүсээс авах авлага	58,528,869.0	58,026,268.8
35	БАРАА МАТЕРИАЛ	757,395,589.0	818,607,468.0
35400	Хангамжийн материал	757,395,589.0	818,607,468.0
35410	Бичиг хэргийн материал	2,500,000.0	2,503,000.0
35420	Аж ахуйн материал	754,895,589.0	816,104,468.0
35440	Түлш, шатах тослох материал	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	9,017,160,920.4	9,436,997,688.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,017,160,920.4	9,436,997,688.3
39200	Биет хөрөнгө	5,015,827,316.6	5,447,247,116.6
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,891,795,050.1	4,911,795,050.1
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(196,570,825.5)	(278,406,298.5)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	262,800,000.0	595,384,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(180,044,444.0)	(268,720,203.3)
39205	Машин тонсг төхөөрөмж(компьютер)	489,809,716.7	696,949,576.7
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(344,494,383.8)	(415,837,708.2)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	247,813,821.6	391,916,821.6
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(191,974,673.8)	(218,216,343.8)
39214	Бусад үндсэн хөрөнгө	58,111,073.0	58,111,073.0
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(21,418,017.6)	(25,728,850.9)
39300	Биет бус хөрөнгө	4,001,333,603.8	3,989,750,571.7
39301	Программ хангамж	153,548,755.0	153,548,755.0
39302	Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж	(91,719,151.2)	(103,302,183.3)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,939,504,000.0	3,939,504,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	9,886,574,767.3	10,628,657,153.6
4	НИЙТ ӨР ТЭЛБӨР (IV)	68,895,761.0	185,230,027.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТЭЛБӨР	68,895,761.0	185,230,027.9
41300	Өглөг	68,895,761.0	185,230,027.9
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	134,347,240.0
41311	Цалингийн өглөг	0.0	(0.0)
41312	НДШ-ийн өглөг	(0.0)	85,248,448.0
41313	ХАОАТ-ын өглөг	-	49,098,792.0
41314	ҮЭ-ийн өглөг	(0.0)	0.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	68,895,761.0	50,342,687.5
413204	Цэвэр, бохир усны өглөг	-	4,671,480.0
413205	Тээвэр, шатахууны өглөг	13,793,407.0	22,039,268.7
413203	Түлш халаалтын өглөг	50,318,354.0	10,191,073.9
413206	Шуудан холбооны өглөг	-	1,100,864.9
413207	Албан томилолтын өглөг	4,784,000.0	12,340,000.0
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	(0.0)	(0.0)
41360	Бусад өглөг	-	540,100.5
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	540,100.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	9,817,679,006.3	10,443,427,125.6
51	Засгийн газрын хувь оролцоо	9,817,679,006.3	10,443,427,125.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,462,089,412.5	1,462,089,412.5

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,462,089,412.5	1,462,089,412.5
51200	Хуримтлагдсан үр дүн	7,865,317,165.3	8,491,065,284.7
51210	Өмнөх үеийн үр дүн	4,775,203,019.6	7,865,317,165.3
51220	Тайлант үеийн үр дүн	3,090,114,145.7	625,748,119.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	490,272,428.5	490,272,428.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	9,886,574,767.3	10,628,657,153.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,074,710,393.0	7,034,434,688.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,638,928,442.0	661,628,309.9
1200	Нийтлэг татварын бус орлого	3,638,928,442.0	661,628,309.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,638,928,442.0	661,628,309.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	13,179,056.0	15,265,300.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,625,749,386.0	646,363,009.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,435,781,951.0	6,372,806,379.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	577,809,751.0	592,901,096.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	79,896,800.0	176,103,035.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	431,568,300.0	101,964,400.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	66,344,651.0	314,471,061.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	362,600.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,857,972,200.0	5,779,905,283.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,857,972,200.0	5,779,905,283.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	5,611,373,965.4	6,408,686,569.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,611,373,965.4	6,408,686,569.6
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,377,702,795.9	6,080,818,733.4
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,567,095,580.5	2,373,790,523.4
210101	Үндсэн цалин	901,684,323.6	2,373,790,523.4
210102	Нэмэгдэл	518,863,634.8	-
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	58,222,056.0	-
210104	Урамшуулал	88,325,566.0	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	178,524,531.4	270,168,155.0
210201	Тэтгэврийн даатгал	165,347,059.4	270,168,155.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,094,035.0	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,278,365.0	-
210204	Ажилгүйдлийн даатгал	565,311.0	-
210205	Эрүүл мэндийн даатгал	6,239,761.0	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	325,371,490.9	360,027,436.2
210301	Гэрэл, цахилгаан	26,336,810.4	24,306,646.1
210302	Түлш, халаалт	265,017,508.6	298,971,594.1
210303	Цэвэр, бохир ус	34,017,172.0	36,749,196.0
2104	Хангамж, бараа материалын зардал	228,004,526.5	344,785,359.7
210401	Бичиг хэрэг	25,326,600.0	26,854,550.0
210402	Тээвэр, шатахуун	183,780,836.0	284,550,772.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,147,090.6	22,314,036.8
210404	Ном, хэвлэл	750,000.0	2,500,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	8,566,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,073,800.0	78,207,285.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,305,100.0	4,300,000.0
210604	Урсгал засвар	20,768,700.0	73,907,285.0

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	63,348,950.0	92,555,700.0
210702	Дотоод албан томилолт	63,348,950.0	92,555,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,420,903,839.0	2,059,473,842.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,401,416,820.0	2,059,473,842.8
210807	Газрын төлбөр	19,487,019.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	564,380,077.5	501,810,431.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	365,093,578.0	201,322,188.0
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	47,477,600.0	44,256,660.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	151,808,899.5	256,231,583.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	233,671,169.5	327,867,836.2
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	65,548,069.51	89,539,715.2
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,548,069.51	89,539,715.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	168,123,100.0	238,328,121.0
213204	Ажил олгогчосс олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	105,045,600.0
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	143,277,359.0	108,199,071.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,845,741.0	25,083,450.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	373,222,281.8	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	3,463,336,427.6	625,748,119.3
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	373,222,281.8	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	373,222,281.8	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	373,222,281.8	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	3,090,114,145.7	625,748,119.3

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,571,306,405.0	6,384,809,744.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	121,144,056.0	23,865,300.0
1200	Нийтлэг татварын бус орлого	121,144,056.0	23,865,300.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	121,144,056.0	23,865,300.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	121,144,056.0	23,865,300.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,450,162,349.0	6,360,944,444.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	592,190,149.0	581,039,161.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	78,652,000.0	164,241,100.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	447,193,498.0	101,964,400.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	66,344,651.0	314,471,061.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	362,600.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,857,972,200.0	5,779,905,283.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,857,972,200.0	5,779,905,283.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	5,508,928,405.0	6,194,868,244.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,508,928,405.0	6,194,868,144.0
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,272,557,235.5	5,865,000,307.7
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,537,287,859.4	2,292,743,180.4
210101	Үндсэн цалин	871,993,998.8	1,313,721,876.9
210102	Нэмэгдэл	518,863,635.3	718,063,673.7
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	58,222,056.5	185,306,133.3
210104	Урамшуулал	88,208,168.8	75,651,496.6

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	171,843,753.5	215,712,920.0
210201	Тэтгэврийн даатгал	158,666,281.5	170,617,614.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,094,035.0	6,051,665.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,278,365.0	2,800,000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	565,311.0	2,800,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,239,761.0	33,443,641.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	275,053,137.0	395,483,236.3
210301	Гэрэл, цахилгаан	26,336,810.4	24,306,646.1
210302	Түлш, халаалт	214,699,154.6	339,098,874.2
210303	Цэвэр, бохир ус	34,017,172.0	32,077,716.0
2104	Хангамж, бараа материалын зардал	180,152,421.6	157,063,392.0
210401	Бичиг хэрэг	25,185,100.0	24,243,400.0
210402	Тээвэр, шатахуун	136,070,231.0	97,790,820.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,147,090.6	21,213,172.0
210404	Ном, хэвлэл	750,000.0	5,000,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	8,816,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,451,200.0	83,978,490.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,425,100.0	5,172,000.0
210602	Тавилга	-	5,179,800.0
210604	Урсгал засвар	26,026,100.0	73,626,690.0
2107	Томилолт, зочны зардал	58,564,950.0	84,999,700.0
210702	Дотоод албан томилолт	58,564,950.0	84,999,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,483,035,669.0	2,347,101,201.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,463,548,650.0	2,347,101,201.0
210807	Газрын төлбөр	19,487,019.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	531,168,245.0	287,918,188.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	483,170,645.0	240,634,728.0
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	47,997,600.0	47,283,460.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	236,371,169.5	329,867,836.3
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	65,548,069.5	89,539,715.3
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,548,069.5	89,539,715.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	170,823,100.0	240,328,121.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	105,045,600.0
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	143,277,359.0	108,199,071.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,545,741.0	27,083,450.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III-I-II)	62,378,000.0	189,941,499.5
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	100.5
140	Төсөвт байгууллагын орлого	-	100.5
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	62,378,000.0	189,941,600.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	62,378,000.0	189,941,600.0
223	БУСАД ХӨРӨНГӨ	62,378,000.0	189,941,600.0
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	62,378,000.0	189,941,600.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(62,378,000.0)	(189,941,600.0)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	(100.5)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(100.5)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

ГАА-2024/171/НА-СТА-ТШЗ

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	НИЙТ ДҮН
1	2023 оны 1-р сарын 1-ний үдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	2023 оны 12-р сарын 31-ний үдэгдэл	1,462,089,412.5	490,272,428.5	7,865,317,165.3	9,817,679,006.3
6	2024 оны 1-р сарын 1-ний үдэгдэл	1,462,089,412.5	490,272,428.5	7,865,317,165.3	9,817,679,006.3
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,462,089,412.5	490,272,428.5	7,865,317,165.3	9,817,679,006.3
9	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
10	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
11	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
12	Тайлант үеийн үр дүн	-	-	625,748,119.3	625,748,119.3
13	2024 оны 12-р сарын 31-ний үдэгдэл	1,462,089,412.5	490,272,428.5	8,491,065,284.7	10,443,427,125.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

ЭЗА	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,570,348,500.0	5,726,455,402.74	843,893,097.26	87%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,570,348,500.0	5,726,455,402.7	843,893,097.3	87%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,273,155,900.0	5,486,127,281.74	787,028,618.3	87%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,383,350,000.0	2,292,743,180.42	90,606,819.6	96%
210101	Үндсэн цалин	2,383,350,000.0	1,313,721,876.91	1,069,628,123.1	55%
210102	Нэмэгдэл	-	718,063,673.70	(718,063,673.7)	#DIV/0!
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	185,306,133.26	(185,306,133.3)	#DIV/0!
210104	Урамшуулал	-	75,651,496.55	(75,651,496.6)	#DIV/0!
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	298,543,900.0	215,712,920.00	82,830,980.0	72%
210201	Тэтгэврийн даатгал	200,649,800.0	170,617,614.00	30,032,186.0	85%
210202	Тэтгэмжийн даатгал	24,473,500.0	6,051,665.00	18,421,835.0	25%
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,236,800.0	2,800,000.00	9,436,800.0	23%
210204	Ажилгүйдлийн даатгал	12,236,800.0	2,800,000.00	9,436,800.0	23%
210205	Эрүүл мэндийн даатгал	48,947,000.0	33,443,641.00	15,503,359.0	68%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	467,689,000.0	395,483,236.33	72,205,763.7	85%
210301	Гэрэл, цахилгаан	30,000,000.0	24,306,646.12	5,693,353.9	81%
210302	Түлш, халаалт	397,689,000.0	339,098,874.21	58,590,125.8	85%
210303	Цэвэр, бохир ус	40,000,000.0	32,077,716.00	7,922,284.0	80%
2104	Хангамж, бараа материалын зардал	163,000,000.0	155,963,391.99	7,036,608.0	96%
210401	Бичиг хэрэг	28,000,000.0	24,243,400.00	3,756,600.0	87%
210402	Тээвэр, шатахуун	100,000,000.0	96,690,820.00	3,309,180.0	97%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,000,000.0	21,213,171.99	(213,172.0)	101%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,000,000.0	8,816,000.00	184,000.0	98%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	270,000,000.0	266,414,090.00	3,585,910.0	99%
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000,000.0	76,728,600.00	23,271,400.0	77%
210602	Тавилга	100,000,000.0	116,058,800.00	(16,058,800.0)	116%

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	70,000,000.0	73,626,690.00	(3,626,690.0)	105%
2107	Томилолт, зочны зардал	85,000,000.0	84,999,700.00	300.0	100%
210702	Дотоод албан томилолт	85,000,000.0	84,999,700.00	300.0	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,289,573,000.0	1,871,527,043.00	418,045,957.0	82%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,289,573,000.0	1,871,527,043.00	418,045,957.0	82%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	316,000,000.0	203,283,720.00	112,716,280.0	64%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	246,000,000.0	156,000,260.00	89,999,740.0	63%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	70,000,000.0	47,283,460.00	22,716,540.0	68%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	297,192,600.00	240,328,121.00	56,864,479.00	81%
2132	Бусад урсгал шилжүүлэг	297,192,600.0	240,328,121.00	56,864,479.0	81%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	164,847,000.0	108,199,071.00	56,647,929.0	66%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,300,000.0	27,083,450.00	216,550.0	99%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,570,348,500.0	5,726,455,402.74	843,893,097.3	87%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,570,348,500.0	5,726,455,402.74	843,893,097.3	87%
132001	Орон нутгийн төсвөөс	6,570,348,500.0	5,726,455,402.74	843,893,097.3	87%

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

ЭЗА	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	568,814,626.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	568,814,626.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	568,814,626.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,100,000.0
210402	Тээвэр, шатахуун	1,100,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	479,009,626.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	479,009,626.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,705,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,705,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	568,814,626.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	568,814,626.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	152,379,165.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,964,400.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	314,471,061.0

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 362.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Өөрийн орлого 362.2 мянган төгрөгийг авлагаар тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 841,804.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 841,704.3 мянган төгрөгийн 17 зөрчил² илэрч 23,417.7 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 818,386.6 мянган төгрөгийн 11 зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 2 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлагыг тус тус хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль болон баталсан бүтэц орон тооны хязгаарыг зөрчин аймгийн Засаг даргын орлогч 1-ээр илүү, зөвлөх ажиллуулан 8,225.6 мянган төгрөгийн цалин олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно", 5.3-т "Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Ажиллагсдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 158.5 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3. Жилийн эцэст 6,750.0 мянган төгрөгийг касст бэлнээр гаргаж авсан бөгөөд анхан шатны баримтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7. Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

4. Жилийн эцэст 8,283.6 мянган төгрөгийг сумын шатахуун түгээх станцын дансанд шилжүүлж, шууд зардлаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Албан хаагчдад 4,680.0 мянган төгрөгөөр спортын хувцас хэрэгсэл, 4,160.0 мянган төгрөгөөр бомбор худалдан авч төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Ном хэвлэлийн зардлаас 5,000.0 мянган төгрөгийн сэтгүүл ном худалдан авсан нь хэрэгцээ шаардлагагүй /дууны ном, сэтгүүл/ төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Тэтгэвэрт гарах эрх үүсээгүй 1 ажилтанд 20,000.0 мянган төгрөгийг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлаас зориулалт бусаар олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Бараа ажил үйлчилгээний зардлаас 26,532.6 мянган төгрөгийг анхан шатны зарцуулалтын баримтгүй, шууд зардлаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5. Бараа ажил үйлчилгээний зардлаас эдийн засгийн ангилал зөрчин 17,333.2 мянган төгрөгийг бэлэг, сэлбэг хэрэгсэл худалдан авахад, хөдөө орон нутагт ажилласны тэтгэмжийн зардлаас 6,130.7 мянган төгрөгийг тусламж, замын зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаал "Ангилал шинэчлэн батлах тухай" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

6. Бичиг хэргийн зардлаас 24,243.4 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардлаас 76,728.6 мянган төгрөг, урсгал засварын зардлаас 73,626.7 мянган төгрөг, тавилга хэрэгслийн зардлаас 39,158.8 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

7. Төрийн өндөр албан тушаалтан, яамдын сайд нар ирэхэд 31,417.9 мянган төгрөгийн буудал, хоол, бэлэгний мөнгийг төсвөөс гаргасан боловч анхан шатны зарцуулалтын баримтгүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

8. Тайлант онд цалингаас суутгасан ХХОАТ 85,248.2 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэл 49,098.8 мянган төгрөгийг төлөөгүй, өр үүсгэж, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

9. Тайлант онд зарцуулсан шатахууны зардлын 22 хувь буюу 76,038.1 мянган төгрөгийг ажиллагсад албан хаагчдын машинд, 62 хувь буюу 153,931.4 мянган төгрөгийг гадны машинд шатахуун хийн зарцуулсан боловч жолоочийн тооцооны хуудсанд хаашаа ямар ажилаар явсан нь тодорхой бус, тооцоо бодоогүй, эд хариуцагч шатахууныг зарцуулалтыг хөтлөхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууны зарцуулалтыг хөтлөөгүй нярав, тооцоо бодоогүй нягтлан бодогч нарт сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

10. Нэгдсэн үндэсний байгууллагаас Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон нийт санхүүжилт 145,240.3 мянган төгрөгийн 69 хувь буюу 100,335.1 мянган төгрөгийг шууд зардалд тайлагнаж, 9,000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар Жангар арга хэмжээнд зарцуулж, 37,500.0 мянган төгрөгийг өөрийн болон хамаарал бүхий этгээдийн дансаар дамжуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

11. Засаг даргын нөөц, хөрөнгөнөөс 91,732.1 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйл, контент, мэдээ бэлтгэх болон бусад арга хэмжээнд нотлох баримтгүйгээр зориулалт бусаар зарцуулсан, Зэгүн пресс ХХК-руу 9,028.8 мянган төгрөгийн тээврийн хөлс шилжүүлсэн боловч гэрээгүй, нотлох баримтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" , Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Аймгийн Засаг даргын тамгын газр	Өөрийн орлого 362.2 мянган төгрөгийг авлагаар тусгасан.	1	362.2			1	362.2	1	362.2				
	дүн	1	362.2			1	362.2	1	362.2				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Аймгийн Засаг даргын тамгын газр	Төрийн хэмнэлтийн тухай хууль болон баталсан бүтэц орон тооны хязгаарыг зөрчин аймгийн Засаг даргын орлогч 1-ээр илүү, зөвлөх ажиллуулан 8,225.6 мянган төгрөгийн цалин олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	8,225.6	1	8,225.6					-	-	-
	Ажиллагсдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 158.5 мянган төгрөгийг илүү олгосон.	1	158.5	1	158.5					-	-	-
	Жилийн эцэст 6,750.0 мянган төгрөгийг касст бэлнээр гаргаж авсан бөгөөд анхан шатны баримтгүй.	1	6,750.0	1	6,750.0					-	-	-
	Албан хаагчдад 4,680.0 мянган төгрөгөөр спортын хувцас хэрэгсэл, 4,160.0 мянган төгрөгөөр бомбор худалдан авч төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	8,840.0	-	-	1	8,840.0			-	-	-

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан


Жилийн эцэст 8,283.6 мянган төгрөгийг сумын ШТС-ын дансанд шилжүүлж, шууд зардлаар тайлагнасан.	1	8,283.6	1	8,283.6	-	-	-	-	-
Ном хэвлэлийн зардлаас 5,000.0 мянган төгрөгийн сэтгүүл ном худалдан авсан нь хэрэгцээ шаардлагагүй /дууны ном, сэтгүүл/ төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	5,000.0	-	-	1	5,000.0	-	-	-
Тэтгэвэрт гарах эрх үүсээгүй 1 ажилтанд 20,000.0 мянган төгрөгийг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлаас зориулалт бусаар олгосон.	1	20,000.0	-	-	1	20,000.0	-	-	-
Бараа ажил үйлчилгээний зардлаас 26,532.6 мянган төгрөгийг анхан шатны зарцуулалтын баримтгүй, шууд зардлаар тайлагнасан.	1	26,532.6	-	-	1	26,532.6	-	-	-
Бараа ажил үйлчилгээний зардлаас эдийн засгийн ангилал зөрчин 17,333.2 мянган төгрөгийг бэлэг, сэлбэг хэрэгсэл худалдан авахад, хөдөө орон нутагт ажилласны тэтгэмжийн зардлаас 6,130.7 мянган төгрөгийг тусламж, замын зардалд зарцуулжээ.	1	23,463.9	-	-	1	23,463.9	-	-	-
Бичиг хэргийн зардлаас 24,243.4 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардлаас 76,728.6 мянган төгрөг, урсгал засварын зардлаас 73,626.7 мянган төгрөг, тавилга хэрэгслийн зардлаас 39,158.8 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.	1	213,757.5	-	-	1	213,757.5	-	-	-
Төрийн өндөр албан тушаалтан, яамдын сайд нар ирэхэд 31,417.9 мянган төгрөгийн буудал, хоол, бэлгийн мөнгийг төсвөөс гаргасан боловч анхан шатны зарцуулалтын баримтгүй	1	31,417.9	-	-	1	31,417.9	-	-	-
Тайлант онд цалингаас суутгасан ХХОАТ 85,248.2 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэл 49,098.8 мянган төгрөгийг төлөөгүй, өр үүсгэж, төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	134,347.2	-	-	1	134,347.2	-	-	-

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Тайлант онд зарцуулсан шатахууны зардлын 22 хувь буюу 76,038.1 мянган төгрөгийг ажиллагсад албан хаагчдын машинд, 62 хувь буюу 153,931.4 мянган төгрөгийг гаднын машинд шатахуун хийн зарцуулсан боловч жолоочийн тооцооны хуудсанд хаашаа ямар ажлаар явсан нь тодорхой бус, тооцоо бодоогүй, эд хариуцагч шатахууныг зарцуулалтыг хөтөлдөггүй байна.	1	153,931.4	-	-	1	153,931.4	-	-	-	-
Нийт		13	640,708.3	4	23,417.7	9	617,290.6		-	-	-

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Аймгийн Засаг даргын тамгын газар	Шилэн дансанд таван саяас дээш 372 гүйлгээний 10,624,772.3 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 1,115,383.3 мянган төгрөгийн 115 захирамж, тушаалыг мэдээлээгүй байна.	1	-			1	-				-	-
	Нэгдсэн үндэсний байгууллагаас Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон нийт санхүүжилт 145,240.3 мянган төгрөгийн 69 хувь буюу 100,335.1 мянган төгрөгийг шууд зардалд тайлагнаж, 9,000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар Жангар арга хэмжээнд зарцуулж, 37,500.0 мянган төгрөгийг өөрийн болон хамаарал бүхий этгээдийн дансаар дамжуулсан байна.	1	100,335.1			1	100,335.1				-	-
	Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 91,732.1 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйл, хоол, буудлын төлбөр, контент, мэдээ бэлтгэх болон бусад арга хэмжээнд			100,760.9				100,760.9			-	-



Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	нотлох баримтгүйгээр зориулалт бусаар зарцуулсан, Зэгүн пресс ХХК-руу 9,028.8 мянган төгрөгийн тээврийн хөлс шилжүүлсэн боловч гэрээгүй, нотлох баримтгүй.	1			1				
Нийт		3	201,096.0		3	201,096.0			

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		